



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 167

Улаанбаатар хот

Албан томилолтоор ажиллуулах  
тухай

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дах заалтыг үндэслэн  
ТУШААХ нь:

1. Тайваны сургалтын төвийн урилгаар тус улсын Үндэсний их сургуулийн эмнэлэгтэй танилцах, албан хэргийн уулзалтад оролцох зорилгоор Улсын гуравдугаар төв эмнэлгийн дарга Ц.Төмөр-Очирт 2015 оны 04 дүгээр сарын 16-21-ний өдрүүдэд Тайвань улсад албан томилолтоор ажиллахыг зөвшөөрсүгэй.

2. Дээрх хугацаанд эмнэлгийн даргын албан үүргийг тус эмнэлгийн Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга С.Наранцэцэгээр түр орлон гүйцэтгүүлсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга /Б.Эрдэнэчимэг/-д үүрэг болгосугай.

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА